

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
8 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ

2024.06.03

Хугацаа 60 минут

А хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Нэгдүгээр хэсэг 35 даалгавар 70 оноо

Хоёрдугаар хэсэг 5 даалгавар 30 оноо

Анги:

Сурагчийн нэр:

Нэгдүгээр хэсэг:

Нэг. Сэргээн санах түвшний даалгавар:

- Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын баруун гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу. (2 оноо)
 - Ордос
 - Халх
 - Урианхай
 - Түмэд
 - Юншээбүү
 - Цахар

A. 1,4,5 B. 2,3,6 C. 2,4,5 D. 1,2,3 E. 1,3,6
- Зон олныг "Хөл хөсөр, гар газар хүртэл жаргуулж" 45 жил хаанчилсан хаан хэн бэ? (2 оноо)
 - Батмөнх даян хаан
 - Түмэн засагт хаан
 - Лигдэн хаан
 - Алтан хан
 - Эсэн тайш
- XVI-XVII зууны үеийн колоничлолд тэргүүлэх үүрэгтэй байсан улсуудыг нэрлэнэ үү. (2 оноо)
 - Португали, Испани
 - Франц, Испани
 - Англи, Нидерланд
 - Франц, Англи
 - Англи, Испани
- Дэлхийг тойрох анхны аяллыг удирдсан Португалийн далайчин хэн бэ? (2 оноо)
 - Ф.Магеллан
 - Х.Колумб
 - Васко да Гама
 - А.Веспучи
 - Аль нь ч биш
- Нийгмийн амьдралыг өөрчилж, орчин үеийн шинжлэх ухааны олон салбарын үндсийг тавьж, хүмүүнлэг үзлийг дэлгэрүүлэн, урлагийг шинэ шатанд гаргасан цаг үе нь ... юм. (2 оноо)
 - Капитализмын үе
 - Сэргэн мандалтын үе
 - Соён гэгээрлийн үе
 - Колоничлолын үе
- ... онд Өвөр Монголын 16 аймгийн 49 хошууны ноёдын чуулган ... болж, Абахайг Монголын хаанаа хэмээн хүлээн зөвшөөрснөөр Өвөр Монгол Манжийн эрхшээлд орсон юм. (2 оноо)
 - 1639 онд Мүгдэнд
 - 1636 онд Долон нуурт
 - 1636 онд Мүгдэнд
 - 1691 онд Мүгдэнд
 - 1691 онд Долон нуурт
- XVIII-XX зуунд Монголд шашны асуудлыг эрхлэн шийддэг төв байгууллагын нэрийг олоорой. (2 оноо)
 - Эрдэнэ Шанзодвагийн яам
 - Хүрээний Манж сайдын газар
 - Бүгд хэргийг түр ерөнхийлөн шийтгэгч яам
 - 13 тамгатай хутагт
- Тод үсгийг хэн зохиосон бэ? (2 оноо)
 - Пагва лам
 - Өндөр гэгээн Занабазар
 - Аюуш гүүш
 - Зая бандида Намхайжамц
 - Агваан лам
- Хаант засгийг дэмжсэн өмнөд нутгийн тайж, газрын эзэд болон парламентыг дэмжсэн төвийн бүсийн хооронд болсон Английн иргэний дайн хэдий хугацаанд болсон бэ? (2 оноо)
 - 1642-1648
 - 1455-1487
 - 1455-1459
 - 1642-1649
- 1727 онд Манж, Орос хоёр улс Буурын гэрээгээр ямар асуудлыг хэлэлцсэн бэ? (2 оноо)
 - Эв найртай зэрэгцэн орших
 - Гадаад Монголын талаар хэлэлцээр
 - Манж улс умард хилээ тогтоох
 - Дэлхийн их гүрэн болоход хамтрах
- XV-XVIII зууны үеийн капитализмын үүсэл болсон орнуудаас аль нь илүүц вэ? (2 оноо)
 - Орос
 - Франц
 - Англи
 - АНУ
 - Бүгд

Хоёр. Ойлгох түвшний даалгавар

Дараах мэдээллийг анхааралтай уншаад, утгыг ухаарч ойлгон, цэгийн оронд тохирох ойлголтыг нөхөж 12, 13, 14 даалгаврыг гүйцэтгээрэй.

Мэдээлэл-1: Зүүн гарын сүүлчийн хаан Даваач 1755 оны 6-р сард 7000 орчм цэрэгтэйгээр Хашин нуурын дэргэд ... (1) их цэргийг ... (2) байлдсан боловч давуу хүчинд цохигдон ялагджээ. Төдөлгүй 1755 оны 7-р сард Даваачийг баривчлан Бээжинд хүргүүлснээр ... (3) газар нутгийг Манжийн цэрэг эзлэн авчээ. Гэвч үүгээр Зүүнгар мөхөөгүй юм.

12. ... (1) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)

- A. Халх Монголын B. Манжийн C. Мин улсын D. Ойрадын E. Өвөр Монголын

13. ... (2) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)
 А. тосон В. тулалдан С. хориглон D. угтан E. дайтан
14. ... (3) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)
 А. Баруун гарын В. Ойрадын С. Халх Монголын D. Зүүн гарын E. Өвөр Монголын
15. НТ 604 онд ханхүү Сётоку Тайси "тэнно" буюу "тэнгэрийн хүү" хэмээх цолыг хэрэглэж эхэлжээ. Дээрх баримтад тохирох зөв хариултыг сонгоно уу? (2 оноо)
 А. Сётоку Тайси тэнгэрээс мэндэлсэн байна.
 В. Япончууд хэт мухар сүсэгт автсан байна.
 С. Төрөө дээдлэх, хамгаалах үзэл бий болсон байна.
 D. Хаант төр бий болсон байна.
16. Нийгмийн дэглэм, хэм хэмжээ бүхэлдээ надаас хамаарна. Үндэсний сонирхол, эрх ашиг, эрх энэ бүхэн миний гарт байна. Төр бол би" (XIV Людовик (1661-1715)-ийн хэлсэн үг) Эх сурвалжийг уншаад энэ үеийн Францын засаглалыг тодорхойлно уу. (2 оноо)
 А. Хаант засаглал В. Хэмжээт эрхт хаант засаглал
 С. Хэмжээгүй эрхт хаант засаглал D. Парламентийн засаглал
17. Ном унших нь язгууртнуудын дунд байдаг зүйл биш болж, дунд ангийг ч хамрах болов. Ном уншдаг хүмүүс нэмэгдэхийн хэрээр ном, тогтмол хэвлэл улам бүр олширч байв. Жишээ нь; Их Британид тогтмол хэвлэлийн тоо 1700 онд 25, 1760 онд 103, 1780 онд 158 болж өсжээ. Сурвалжийн мэдээг уншаад энэхүү үзэгдэл нь юуны илрэл болохыг зөв хариултаас сонгоно уу. (2 оноо)
 А. Хүмүүнлэг үзлийн үр дүн В. Соён гэгээрлийн үр дүн
 С. Сэргэн мандлын үр дүн D. Шинэчлэлийн үр дүн
18. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу. (2 оноо)
 А. Монголын их хааны сүр хүч буурч, эрх мэдлийн хуваарилалт алдагдсан.
 В. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн.
 С. Манж нар монголчуудыг их цэргээр удаа дараа довтолсон.
 D. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн.
 E. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан.
19. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Шашны цаазаар лам нарын эрх, дархыг хуульчлан баталж, дэмжих бодлого явуулсан.
 В. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилготой байсан.
 С. Бөөгийн хойлоглох ёсыг халж хүн нас барахад амьтны амь таслахыг хориглосон нь ард олны сэтгэлд нийцсэн.
 D. Монголчуудыг шашиндаа оруулснаар нөлөөнийхөө хүрээг тэлэх, Төв Азид өөрийн улсын эзлэх байр суурийг өсгөх зорилготой байсан.
 E. Шашин дэлгэрэхэд улсаас эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн.
20. Манжийг эсэргүүцсэн 1755-1758 оны монголчуудын зэвсэгт бослогыг хэн удирдсан бэ? (2 оноо)
 А. Амарсанаа, Чингүнжав нараар удирдуулсан бослого
 В. Энхтайванаар удирдуулсан Улиастайн 2000 цэргийн бослого
 С. Онолтоор удирдуулсан Улиастайн цэргийн бослого
 D. Их Хүрээний лам нарын бослого
 E. То вангийн тэмцэл
21. XVII зуунд Францад яагаад импортын барааны хураамжийг өсгөх бодлого хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)
 А. Дотоодын үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлэх
 В. Дотоодын үйлдвэрлэл, худалдаанд хяналт тавих
 С. Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх
 D. Бусад орноос харилцаагаа таслах
22. I Петр хаан Оросыг хаанчилж байхдаа Оросын газар нутгийг тэлсэн. Тэрээр ямар ямар голын сав нутгийг өөрийн эзэмшилд оруулсан бэ? (2 оноо)
 А. Байгал нуур, Амар мөрөн, Сибирийн тайга
 В. Азов, Хар далай, Балтийн тэнгис
 С. Байгал нуур, Хар далай, Азов
 D. Амар мөрөн, Балтийн тэнгис, Байгал нуур
23. Наполеон Бонапартын Францын эзэнт гүрний түүхэнд оруулсан хувь нэмрийг үнэлнэ үү. (2 оноо)
 А. Францын анхны иргэний хуулийг батлан гаргасан.
 В. Өрнө дахины хаант улсыг эзлэн түрэмгийлж газар нутгаа тэлсэн.
 С. Байлдааны тактик боловсруулдаг байсан.
 D. Орчин үеийн Францын суурийг тавьсан.

Гурав. Хэрэглэх түвшний даалгавар:

24. Монголын хаадын хаан ор суусан оныг Чингисийн онд шилжүүлнэ үү. (2 оноо)
 1. Эсэн хаан 1453 он = Чингисийн он
 2. Лигдэн хаан 1607 он = Чингисийн он
25. Амарсанаагийн уриалгаар эхэлсэн тэмцэл үр дүнд хүрээгүйн гол шалтгаан нь юу вэ? (2 оноо)
 А. Амарсанаагийн удирдаж байсан цэргүүдийн тоо бага байсан.

- V. Босогчид дотоод эв нэгдлээ сахиж, хүчээ нэгтгэж чадахгүй байсан.
 C. Амарсанаа Орос улс руу зугтсан.
 D. Дээрх бүгд
26. Улс төрийн бутралын үед монголчуудыг хэрхэн нэрлэдэг байсан бэ? (2 оноо)
 A. 40 түмэн монгол, 4 түмэн ойрад
 B. 6 түмэн монгол, 4 түмэн ойрад
 C. 4 түмэн монгол, 40 түмэн ойрад
 D. 4 түмэн монгол, 6 түмэн ойрад
 E. Зөв хариулт алга
27. Тухайн үед үйлдвэрийн ажилчид 14-18 цаг ажиллаж байжээ. Яагаад үйлдвэрт хүүхдүүдийг түлхүү ажиллуулж байсан бэ? (2 оноо)
 A. бага үнээр хямдхан
 B. амьдралд нь дэм болохын тулд
 C. дуулгавартай тул
 D. том хүнээс хурдан шаламгай тул
28. Колони орны жишээ аль нь вэ? (2 оноо)
 A. 1858 онд Английн парламент Энэтхэгийг Британы хааны эзэмшил хэмээн нэрлэв.
 B. 1860 онд байгуулсан гэрээгээр Манж Чин улс дайны төлбөрт 8 сая лан мөнгө төлөх болж, гадаад улсуудын бараа бүтээгдэхүүнд зах зээлээ бүрэн нээлттэй болгожээ.
 C. Энэтхэгээс хөвөн зөөвөрлөж, Британид даавуу нэхсэнийгээ Энэтхэгт буцааж зарна. Харин Энэтхэгийн даавууны үйлдвэрлэл уналтад орсны дараа өөрсдийн үйлдвэрээ байгуулдаг байв.
 D. A C хариулт зөв
29. Шинэ засгийн бодлогыг эсэргүүцэх болсон шалтгаан аль нь вэ? (2 оноо)
 A. Монголын хүн амыг олшруулах
 B. Зэвсгийн хүчээр эзлэх
 C. Эрчүүдийг дайнд явуулах
 D. Хүн амыг хятадчилах, тариан талбай болгох
30. Манж Чин гүрэн зах хязгаарын улсаа гадаадын улсад алдахгүйн тулд хятадуудаар дүүргэж тариа тариулах бодлогыг барьж байсан. Иймийн учир 1906 онд "Нүүдлийн иргэдийн хэргийг эрхлэх хороо" байгуулан хятад тариачдыг монголд суурьшуулж эхэлсэн. Энэхүү бодлогыг билгийн тооллоор хэддүгээр жарны ямар жилд явуулсан бэ? (2 оноо)
 A. 14-р жарны морин жил
 B. 14-р жарны хонь жил
 C. 15-р жарны морин жил
 D. 15-р жарны хонь жил
 E. 14-р жарны бич жил
31. Монголд шарын шашин өргөн дэлгэрсний сөрөг талд хамаарахыг олоорой. /2 оноо /
 A. суурин газрууд олноор байгуулагдсан
 B. сүм хийд нь тухайн үеийн боловсрол, соёл, урлагийн төв болсон
 C. эрчүүд олноор лам болж шавилан суусан
 D. монгол, манж, төвд бичгээр ном судар зохиож байсан
32. Хүрээ хийдэд лам нарын тоо олширсон нь ямар сөрөг үр дагаварт хүргэсэн бэ? (2 оноо)
 A. Эрчүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлсэн, хүн амын өсөлт саарсан.
 B. Эрчүүд дайтах чадвараа алдан бусдад дарлагдах болсон.
 C. Мал маллах эрчүүдээр дутаж үйлдвэрлэл зогссон.
 D. Үйлдвэрт ажиллах сонирхолгүй болсон.
33. "Колоничлол" хэмээх үгийн утгыг тайлбарлана уу. (2оноо)

34. Капиталист тогтолцооны онцлолыг тодорхойлсон зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
 A. Нэхмэлийн үйл ажиллагаа цехийн зохион байгуулалтаар явж байв.
 B. Үйлдвэрийн эзэд ашиг их хүртэх болсон.
 C. Хотын хүн амын өсөлт саарах болсон.
 D. Үйлдвэрийн газрыг бэлчээр болгон хувиргах болсон.
35. Соён гэгээрлийн хөдөлгөөнөөр бий болж өнөөдрийн төр засагт уламжлагдан ирсэн үзэл санаа аль нь вэ? Үнэлэлт дүгнэлт өгч зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
 A. Төр бол би.
 B. Эзэн хааны зарлиг бол тэнгэрийн санаа юм.
 C. Төрд хууль үйлчлэх ёстой.
 D. Хүмүүнлэг үзлийг дэлгэрүүлэн урлагийг шинэ шатанд гаргав.

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

Дөрөв. Задлан шинжлэх түвшний даалгавар:

36. Дараах мэдээллийг анхааралтай уншаад, Монгол улстай хиллэж байсан улсуудыг нэрлэж, оюуны зураглал хийгээрэй. (6 оноо)

Мэдээлэл 2: Энэ үед Монгол улсын гадаад орчин тайван биш байв. Монгол улс хойд талаараа Орос улстай хил залган орших болжээ. Зүүн өмнөдөд Манж нар хүчирхэгжиж, өмнөдөд Мин улс доройтож, баруун өмнөдөд Төвөд, баруун талд казак, киргизүүд нутаглаж байв.

37. Дараах мэдээллийг анхааралтай уншаад, хүснэгтэд ялган тоочиж бичээрэй. (6 оноо)

Мэдээлэл 3: Герман, АНУ, Скандинавын орнуудад дэлгэрсэн. 16-р зууны үед Германд дэлгэрч, 1555 онд хүлээн зөвшөөрөгдсөн. М.Лютерийг залгамжлагчид Ромын папын засаглалаас татгалзаж, католик шашны олон дэг журмыг өөрчилсөн. Сүм хийдийн барилгыг энгийн загвартай болгож, хурал номыг үндэсний хэлээр хурах болсон байна. Сүм хийд хөрөнгө хуримтлуулахгүй, буян үйлдэж байх учиртай гэж уриалж байлаа. Хүн өөрийн итгэл үнэмшлээр бурханд хандах учиртай. Хүсэж буй хүмүүст Библийн сургаалын учрыг ойлгоход санваартнууд дэмжлэг үзүүлэх ёстой гэж үзэж байв.

Гол үзэл санаа	Шийдсэн асуудлууд
1.	1.
2.	2.
3.	3.


38. Манжийн 9 эрүү шүүлтээс 6-г нэрлэж бичнэ үү. (2 оноо)

1. 2. 3.
4. 5. 6.

Дараах мэдээллийг анхааралтай уншаад, 39, 40-р даалгаврыг гүйцэтгээрэй. (6 оноо)

Мэдээлэл 4: Их Британий байгаль судлаач Ч.Дарвин олон жилийн ажиглалт, судалгааныхаа үр дүнд туурвисан “Зүйлийн үүсэл” алдарт бүтээлээ 1859 онд гаргаж. Тэрээр өдгөө дэлхий дахинд Дарвины хувьслын онол хэмээн алдаршсан онолоо дэвшүүлэв. 1846 онд Америкийн эмч В.Холмс өвдөлт намдаах үйлчилгээтэй химийн бодисуудыг өвчин намдаагч, бүх мэдрэхүйг үгүй болгодог бодисыг мэдээ алдуулагч гэж нэрлэсэн байна. 1831 онд Америкт Сирьюс Хол МакКормикын бүтээсэн механик ургац хураагч нь гурван хүний ажлыг гүйцэтгэдэг байв. АНУ-д дугуй үйлдвэрлэгч ах дүү Орвил, Вилбур Райт нар 1903 онд анхны нисэх онгоцыг бүтээжээ. 1836 онд Америкийн зохион бүтээгч Семюэл Морзе холбооны шинэ телеграф бүтээж, цахилгаан соронзон аппаратын тусламжтайгаар мэдээллийг цэг, зураасаар тэмдэглэн дамжуулах болжээ. 1876 онд АНУ-д Александр Грэхэм Белл анхны телефон утсыг зохион бүтээсэн байна. 1879 онд харилцах утасны сүлжээ бий болов.

39. Дээрх шинжлэх ухааны ололт, нээлтүүдээс 6-г сонгож, он тооллын шулуун дээр үйл явдлыг нэрлэж, тэмдэглээрэй.



40. Дээрх нээлтийн талаар өөрийн дүгнэлтээ бичээрэй. (6 оноо)

Шинжлэх ухааны ололт, нээлтийн нэр	Өнөө үед хүмүүс хэрхэн ашиглаж байна вэ?	Ач холбогдол нь юу вэ?
Телефон утас	1. 2. 3.	1. 2. 3.

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР



Материал зассан: Багш

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
8 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ

2024.06.03

Хугацаа 60 минут

В хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 100

Нэгдүгээр хэсэг 35 даалгавар 70 оноо

Хоёрдугаар хэсэг 5 даалгавар 30 оноо

Анги:

Сурагчийн нэр:

Нэгдүгээр хэсэг:

Нэг. Сэргээн санах түвшний даалгавар:

- Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын зүүн гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу. (2 оноо)
1. Ордос 2. Халх 3. Урианхай 4. Түмэд 5. Юншээбүү 6. Цахар
A. 2,4,5 B. 1,4,5 C. 2,3,6 D. 1,2,3 E. 4,5,6
- Хэн хааны үеэс Монголын хаан ширээ, хасбуу тамга Цахар түмэн рүү шилжсэн бэ? (2 оноо)
A. Боди Алаг хаан B. Түмэн засагт хаан C. Лигдэн хаан
D. Алтан хан E. Эсэн тайш
- XV-XVI зууны үеийн колоничлолд тэргүүлэх үүрэгтэй байсан улсуудыг нэрлэнэ үү. (2 оноо)
A. Португали, Испани B. Франц, Испани C. Англи, Нидерланд
D. Франц, Англи E. Англи, Испани
- Америк тивд Европчуудаас анх удаа хөл тавьсан Итали гаралтай далайчин хэн бэ?
A. Ф.Магеллан B. Х.Колумб C. Васко да Гама D. А.Веспучи E. Аль нь ч биш
- Хүн төрөлхтний оюун санаа, нийгмийн амьдрал, сэтгэлгээнд гарсан өөрчлөлтийн цаг үе нь ... юм.
A. Капитализмын үе B. Сэргэн мандалтын үе
C. Соён гэгээрлийн үе D. Колоничлолын үе
- ... онд Манжийн Энх-Амгалан хаан Халхын 500-аад ноёд, тайж, Өвөр Монголын 49 хошууны нөлөө бүхий ноёдын чуулганыг ... зохион байгуулж, Халх Монголыг Манж Чин улсын харьяанд орсныг албан ёсоор тунхаглан зарлажээ. (2 оноо)
A. 1639 онд Мүгдэнд B. 1636 онд Долон нуурт C. 1636 онд Мүгдэнд
D. 1691 онд Мүгдэнд E. 1691 онд Долон нуурт
- Манжийн эрхшээлийн үед Монголыг захирч байсан хамгийн дээд байгууллага ямар нэртэй байсан бэ? (2 оноо)
A. Улиастайн Манж сайдын газар
B. Гадаад Монголын төрийг засах явдлын яам
C. Хүрээний Манж сайдын газар
D. Бээжингийн Төв засгийн газар
- Соёмбо үсгийг хэн зохиосон бэ? (2 оноо)
A. Зая бандида Намхайжамц B. Өндөр гэгээн Занабазар
C. Аюуш гүүш D. Пагва лам E. Агваан лам
- Хаант засгийг дэмжсэн өмнөд нутгийн тайж, газрын эзэд болон парламентыг дэмжсэн төвийн бүсийн хооронд болсон Английн иргэний дайн хэдий хугацаанд болсон бэ? (2 оноо)
A. 1642-1649 B. 1455-1487 C. 1455-1459 D. 1642-1648
- 1727 онд Манж, Орос хоёр улс Буурын гэрээгээр ямар асуудлыг хэлэлцсэн бэ? (2 оноо)
A. Эв найртай зэрэгцэн орших B. Манж улс умард хилээ тогтоох
C. Гадаад Монголын талаар хэлэлцээр D. Дэлхийн их гүрэн болоход хамтрах
- XV-XVIII зууны үеийн капитализмын үүсэл болсон орнуудаас аль нь илүүц вэ? (2 оноо)
A. АНУ B. Франц C. Англи D. Орос E. Бүгд

Хоёр. Ойлгох түвшний даалгавар

Дараах мэдээллийг анхааралтай уншаад, утгыг ухаарч ойлгон, цэгийн оронд тохирох ойлголтыг нөхөж 12, 13, 14 даалгаврыг гүйцэтгээрэй.

Мэдээлэл-1: 1632 оны 4-р сард Абахай Лигдэнг бүр мөсөн гэнэдүүлэн цохихоор өөрийн биеэр цэрэг удирдан довтолжээ. Манж цэргийн бүрэлдэхүүнд явсан хоёр ... (1) цэрэг нууцаар мэдээ хүргэснээр Лигдэн гарз хохирлоос зайлж, ... (2) зүг бууруулан одов. Зам зуураа Ордост байсан Чингисийн онгоны өмнө ёслол үйлдсэнээс гадна онгоныг авч явахыг оролдсон байна. Лигдэн Хөх

нуурт явах замдаа 1634 онд Шар тал гэдэг газар цэцэг өвчнөөр нас эцэслэснээр Монгол улс хаангүй, ... (3) толгойлох эзэнгүй болов.

12. ... (1) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)
A. Халх Монгол B. Ойрад C. Монгол D. Манж E. Өвөр Монгол
13. ... (2) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)
A. Долон нуурын B. Хөх нуурын C. Шар мөрний D. Шар талын E. Ордосын
14. ... (3) тохирохыг нөхөж бичээрэй. (2 оноо)
A. Өвөр Монгол B. Халх Монгол C. Зүүн гар D. Монголчууд E. Ойрад
15. НТ 604 онд ханхүү Сётоку Тайси "тэнно" буюу "тэнгэрийн хүү" хэмээх цолыг хэрэглэж эхэлжээ. Дээрх баримтад тохирох зөв хариултыг сонгоно уу? (2 оноо)
A. Сётоку Тайси тэнгэрээс мэндэлсэн байна.
B. Япончууд хэт мухар сүсэгт автсан байна.
C. Төрөө дээдлэх, хамгаалах үзэл бий болсон байна.
D. Хаант төр бий болсон байна.
16. Нийгмийн дэглэм, хэм хэмжээ бүхэлдээ надаас хамаарна. Үндэсний сонирхол, эрх ашиг, эрх энэ бүхэн миний гарт байна. Төр бол би" (XIV Людвик (1661-1715)-ийн хэлсэн үг) Эх сурвалжийг уншаад энэ үеийн Францын засаглалыг тодорхойлно уу. (2 оноо)
A. Хаант засаглал B. Хэмжээт эрхт хаант засаглал
C. Хэмжээгүй эрхт хаант засаглал D. Парламентийн засаглал
17. Ном унших нь язгууртнуудын дунд байдаг зүйл биш болж, дунд ангийг ч хамрах болов. Ном уншдаг хүмүүс нэмэгдэхийн хэрээр ном, тогтмол хэвлэл улам бүр олширч байв. Жишээ нь; Их Британид тогтмол хэвлэлийн тоо 1700 онд 25, 1760 онд 103, 1780 онд 158 болж өсжээ. Сурвалжийн мэдээг уншаад энэхүү үзэгдэл нь юуны илрэл болохыг зөв хариултаас сонгоно уу. (2 оноо)
A. Хүмүүнлэг үзлийн үр дүн B. Соён гэгээрлийн үр дүн
C. Сэргэн мандлын үр дүн D. Шинэчлэлийн үр дүн
18. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгааныг олно уу. (2 оноо)
A. Зүүнгар улс болон Халх Монгол хоорондоо эв түнжингүй байсан.
B. Халхын баруун, зүүн гар хоорондоо дайсагнасан байдалтай байсан.
C. Манж нар хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлого явуулсан.
D. Монголчууд Мин улстай худалдаа арилжаа хийж байсан.
E. Монголын их хааны засаглал суларсан.
19. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн дотоод хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
A. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилгодоо шашныг ашиглаж байжээ.
B. XVI зууны сүүл үеэс бурхны шашны шар, улааны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхээр өрсөлдөх болжээ.
C. Төвөд улсын шашны урсгалууд монголчуудаас цэрэг, эдийн засгийн дэмжлэг хайж байжээ.
D. Төвөд, Мин улсын түрэмгийллээс өөрсдийгөө хамгаалахын тулд гаднаас цэрэг, эдийн засгийн тусламж хайж байжээ.
E. Монголын мал сүрэг, алт мөнгө нь Төвөдийн шар, улааны урсгалуудад томоохон дэмжлэг болжээ.
20. Манжийг эсэргүүцсэн 1800 оны монголчуудын зэвсэгт бослогыг хэн удирдсан бэ? (2 оноо)
A. Амарсанаа, Чингүнжав нараар удирдуулсан бослого
B. Энхтайванаар удирдуулсан Улиастайн 2000 цэргийн бослого
C. Онолтоор удирдуулсан Улиастайн цэргийн бослого
D. Их Хүрээний лам нарын бослого
E. То вангийн тэмцэл
21. XVII зуунд Францад яагаад импортын барааны хураамжийг өсгөх бодлого хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)
A. Дотоодын үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлэх
B. Дотоодын үйлдвэрлэл, худалдаанд хяналт тавих
C. Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх
D. Бусад орноос харилцаагаа таслах
22. I Петр хаан Орос улсад үйлдвэр сул хөгжиж Европын хараат байдалтай байгаад анхаарал хандуулж аж үйлдвэрийг хөгжүүлэх ямар бодлогыг хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)
A. Гадаадын хөрөнгө оруулах, зээл олгох
B. Дотооддоо боловсруулах, хөнгөлөлт олгох
C. Гадаадын дэмжлэг авах, хөнгөлөлт олгох
D. Дотооддоо боловсруулах, зээл олгох
23. Наполеон Бонапартын үед Францын шинэ Үндсэн хуулийг гаргахын зэрэгцээ бусад ямар ямар хуулийг гаргасан бэ? (2 оноо)
A. Эрүүгийн, Иргэний ба гэр бүлийн, Эрх чөлөөний тунхаглал
B. Эрх чөлөөний тунхаглал, Эрүүгийн, Боловсролын хууль
C. Иргэний ба гэр бүлийн, Эрүүгийн, Худалдааны хууль
D. Эрүүгийн, Боловсролын, Худалдааны хууль

Гурав. Хэрэглэх түвшний даалгавар:

24. Монголын хаадын хаан ор суусан оныг Чингисийн онд шилжүүлнэ үү. (2 оноо)
1. Батмөнх даян хаан 1470 он = Чингисийн он
 2. Түмэн засагт хаан 1557 он = Чингисийн он
25. Амарсанаагийн уриалгаар эхэлсэн тэмцэл үр дүнд хүрээгүйн гол шалтгаан нь юу вэ? (2 оноо)
- A. Амарсанаагийн удирдаж байсан цэргүүдийн тоо бага байсан.
 - B. Босогчид дотоод эв нэгдлээ сахиж, хүчээ нэгтгэж чадахгүй байсан.
 - C. Амарсанаа Орос улс руу зугтсан.
 - D. Дээрх бүгд
26. Улс төрийн бутралын үед монголчуудыг хэрхэн нэрлэдэг байсан бэ? (2 оноо)
- A. 40 түмэн монгол, 4 түмэн ойрад
 - B. 6 түмэн монгол, 4 түмэн ойрад
 - C. 4 түмэн монгол, 40 түмэн ойрад
 - D. 4 түмэн монгол, 6 түмэн ойрад
 - E. Зөв хариулт алга
27. Тухайн үед үйлдвэрийн ажилчид 14-18 цаг ажиллаж байжээ. Хүүхдийн ажиллаж байсан орчин ямар байсан талаар дүгнэлт өгнө үү. (2 оноо)
- A. ажиллах цаг богино, харанхуй, заваан, аймшигтай
 - B. ажиллах цаг урт, ажиллах нөхцөл хүнд, заваан, аймшигтай
 - C. ажиллах нөхцөл хүнд, харанхуй, заваан, аймшигтай
 - D. ажиллах цаг урт, гэрэлтэй, тохилог, ая тухтай
28. . Колони орны жишээ аль нь вэ? (2 оноо)
- A. 1858 онд Английн парламент Энэтхэгийг Их Британы хааны эзэмшил хэмээн нэрлэв.
 - B. 1860 онд байгуулсан гэрээгээр Манж Чин улс дайны төлбөрт 8 сая лан мөнгө төлөх болж, гадаад улсуудын бараа бүтээгдэхүүнд зах зээлээ бүрэн нээлттэй болгожээ.
 - C. Энэтхэгээс хөвөн зөөвөрлөж, Британид даавуу нэхсэнийгээ Энэтхэгт буцааж зарна. Харин Энэтхэгийн даавууны үйлдвэрлэл уналтад орсны дараа өөрсдийн үйлдвэрээ байгуулдаг байв.
 - D. А С хариулт зөв
29. Шинэ засгийн бодлогыг эсэргүүцэх болсон шалтгаан аль нь вэ? (2 оноо)
- A. Монголын хүн амыг олшруулах
 - B. Зэвсгийн хүчээр эзлэх
 - C. Эрчүүдийг дайнд явуулах
 - D. Хүн амыг хятадчилах, тариан талбай болгох
30. Манж Чин гүрэн зах хязгаарын улсаа гадаадын улсад алдахгүйн тулд хятадуудаар дүүргэж тариа тариулах бодлогыг барьж байсан. Иймийн учир 1906 онд "Нүүдлийн иргэдийн хэргийг эрхлэх хороо" байгуулан хятад тариачдыг монголд суурьшуулж эхэлсэн. Энэхүү бодлогыг билгийн тооллоор хэддүгээр жарны ямар жилд явуулсан бэ? (2 оноо)
- A. 14-р жарны морин жил
 - B. 14-р жарны хонь жил
 - C. 15-р жарны морин жил
 - D. 15-р жарны хонь жил
 - E. 14-р жарны бич жил
31. Монголд шарын шашин өргөн дэлгэрсний зэрэг талд үл хамаарахыг олоорой. /2 оноо /
- A. суурин газрууд олноор байгуулагдсан
 - B. эрчүүд олноор лам болж шавилан суусан
 - C. сүм хийд нь тухайн үеийн боловсрол, соёл, урлагийн төв болсон
 - D. монгол, манж, төвд бичгээр ном судар зохиож байсан
32. Хүрээ хийдэд лам нарын тоо олширсон нь ямар сөрөг үр дагаварт хүргэсэн бэ? (2 оноо)
- A. Эрчүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлсэн, хүн амын өсөлт саарсан.
 - B. Эрчүүд дайтах чадвараа алдан бусдад дарлагдах болсон.
 - C. Мал маллах эрчүүдээр дутаж үйлдвэрлэл зогссон.
 - D. Үйлдвэрт ажиллах сонирхолгүй болсон.
33. "Колоничлол" хэмээх үгийн утгыг тайлбарлана уу. (2оноо)
-
-
34. Капиталист тогтолцооны онцлогийг тодорхойлсон зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
- A. Нэхмэлийн үйл ажиллагаа цехийн зохион байгуулалтаар явж байв.
 - B. Үйлдвэрийн эзэд ашиг их хүртэх болсон.
 - C. Хотын хүн амын өсөлт саарах болсон.
 - D. Үйлдвэрийн газрыг бэлчээр болгон хувиргах болсон.
35. Соён гэгээрлийн хөдөлгөөнөөр бий болж өнөөдрийн төр засагт уламжлагдан ирсэн үзэл санаа аль нь вэ? Үнэлэлт дүгнэлт өгч зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
- A. Төр бол би.
 - B. Эзэн хааны зарлиг бол тэнгэрийн санаа юм.
 - C. Төрд хууль үйлчлэх ёстой.
 - D. Хүмүүнлэг үзлийг дэлгэрүүлэн урлагийг шинэ шатанд гаргав.

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

Дөрөв. Задлан шинжлэх түвшний даалгавар:

36. Дараах мэдээллийг анхааралтай уншаад, Монгол улстай хиллэж байсан улсуудыг нэрлэж, оюуны зураглал хийгээрэй. (6 оноо)

Мэдээлэл 2: Энэ үед Монгол улсын гадаад орчин тайван биш байв. Монгол улс хойд талаараа Орос улстай хил залган орших болжээ. Зүүн өмнөдөд Манж нар хүчирхэгжиж, өмнөдөд Мин улс доройтож, баруун өмнөдөд Төвөд, баруун талд казак, киргизүүд нутаглаж байв.

37. Дараах мэдээллийг анхааралтай уншаад, хүснэгтэд ялган тоочиж бичээрэй. (6 оноо)

Мэдээлэл 3: Франц, Нидерланд, Шотланд, Англид дэлгэрсэн. Тэд бурхан ба хүний хооронд ямар ч зуучлагч байх учиргүй. Шүтлэг бишрэл нь зөвхөн хүний оюун ухаан, шашны мэдрэмжид тулгуурлах ёстой гэж үзэж байв. Христос сүм хийд нь ёс суртахууны хатуу чанга хэм хэмжээ, зан суртахууныг номлогч байх ёстой гэж тунхаглажээ. Хэрэв хүний ажил үйл сайн байгаа бол бурхан түүнийг энэрэн хайрлаж байгаа бөгөөд түүний өмнө диваажингийн хаалга нээлттэй байх болно, харин ажил үйлс нь бүтэлгүйтэж, золгүй явдал тохиох нь бурхан түүнийг үл таалснаас болж байгаа бөгөөд тэр тамд унах ёстой гэжээ. Үндэслэгч нь Францын хуульч Ж.Кальвин юм. 1559 онд протестант шашныг номлогч бэлтгэх Женевийн академийг үүсгэн байгуулсан. Энэ сургуулийг төгсөгчид Кальвины номлолыг Европ даяар дэлгэрүүлэхэд үүрэг гүйцэтгэсэн.

Гол үзэл санаа	Шийдсэн асуудлууд
1.	1.
2.	2.
3.	3.


38. Монголчуудын Манжид залгуулж байсан алба гувчуураас 6-г нэрлэж бичнэ үү. (6 оноо)

1. 2. 3.
4. 5. 6.

Дараах мэдээллийг анхааралтай уншаад, 39, 40-р даалгаврыг гүйцэтгээрэй. (6 оноо)

Мэдээлэл 4: Их Британий байгаль судлаач Ч.Дарвин олон жилийн ажиглалт, судалгааныхаа үр дүнд туурвисан "Зүйлийн үүсэл" алдарт бүтээлээ 1859 онд гаргав. Тэрээр өдгөө дэлхий дахинд Дарвины хувьслын онол хэмээн алдаршсан онолоо дэвшүүлэв. 1846 онд Америкийн эмч В.Холмс өвдөлт намдаах үйлчилгээтэй химийн бодисуудыг өвчин намдаагч, бүх мэдрэхүйг үгүй болгодог бодисыг мэдээ алдуулагч гэж нэрлэсэн байна. 1831 онд Америкт Сирьюс Хол МакКормикын бүтээсэн механик ургац хураагч нь гурван хүний ажлыг гүйцэтгэдэг байв. АНУ-д дугуй үйлдвэрлэгч ах дүү Орвил, Вилбур Райт нар 1903 онд анхны нисэх онгоцыг бүтээжээ. 1836 онд Америкийн зохион бүтээгч Семюэл Морзе холбооны шинэ телеграф бүтээж, цахилгаан соронзон аппаратын тусламжтайгаар мэдээллийг цэг, зураасаар тэмдэглэн дамжуулах болжээ. 1876 онд АНУ-д Александр Грэхэм Белл анхны телефон утсыг зохион бүтээсэн байна. 1879 онд харилцах утасны сүлжээ бий болов.

39. Дээрх шинжлэх ухааны ололт, нээлтүүдээс 6-г сонгож, он тооллын шулуун дээр үйл явдлыг нэрлэж, тэмдэглээрэй.



40. Дээрх нээлтийн талаар өөрийн дүгнэлтээ бичээрэй. (6 оноо)

Шинжлэх ухааны ололт, нээлтийн нэр	Өнөө үед хүмүүс хэрхэн ашиглаж байна вэ?	Ач холбогдол нь юу вэ?
Нисэх онгоц	1. 2. 3.	1. 2. 3.

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР *Ламдал* Д.БАЙГАЛМАА
Материал зассан: Багш